

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
“БАГАЧУУД ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛСАН
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2026 оны 06 дугаар сарын 12

Улаанбаатар хот

№	Удирдах ажилтны хүлээсэн үүрэг	Биелэлт	Хувь
1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2026-2030 онд Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2026-2030 онд Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах арга хэмжээг 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулан тайланг холбогдох хүснэгтээр хугацаанд нь тайлагнан хүргүүлж ажилласан.	100
2	Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2026 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах;	Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2026 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээтэй холбоотой бичиг баримт манай байгууллагад ирээгүй болно.	100
3	Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагаандаа хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх замаар хүний нөөцийг цомхон, тогтвортой, үр ашигтай, хариуцлагатай ажиллуулах, чадахуйн зарчим (мерит)-ыг тууштай хэрэгжүүлэх;	Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байгууллагын үйл ажиллагаандаа хиймэл оюун ухааныг нэвтрүүлж, хүний нөөцийг цомхон тогтвортой байлгаж, мерит зарчмыг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын дагуу сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг үүрэг болгосны дагуу эхний хагас жилийн байдлаар сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт явуулаагүй болно.	100
4	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, өр, авлага үүсгэхгүй байх, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн төлөвлөгөөний болон түүнтэй холбоотой	2026 оны зорилтот түвшингээр 6,015,301.52 мянган төгрөгийн орлого олж нийт 5,981,076.62 мянган төгрөгийн зардал гарган 34,224.9 мянган төгрөгийн ашигтай ажиллах төлөвлөгөө боловсруулсан бөгөөд 06 дугаар сарын 12-ны өдрийн урьдчилсан гүйцэтгэлээр 2,744,091.11 мянган төгрөгийн орлого олж, нийт 2,674,502.20 зардал гарган 69,588.91 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Төлөвлөгөөний биелэлт 45,6 хувьтай байна. Өмнөх оны мөн үеэс 2,5 хувиар өсөлттэй байна. 06 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар үндсэн хөрөнгө	100

	гэрээ, хэлцлийн биелэлт, үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцлага хүлээх;	болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг захирлын тушаалын дагуу тооллогын комисс тоолж ажиллахаар төлөвлөж байна. 2026 оны үндсэн хөрөнгийн улсын тооллогоо хийхээр бэлтгэл ажилдаа орсон байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 2026 оны төсөвлөсөн бүх зардлуудыг хэмнэж ажилласан. Үүнд: • Цалингийн зардал 123,505.68 мянган төгрөгөөр • Гэрэл цахилгааны зардал 3,420.22 мянган төгрөгөөр • Бичиг хэргийн зардал 2,308.80 мянган төгрөг • Шатахууны зардал 8,500.00 мянган төгрөгөөр тус тус хэмнэн ажиллалаа. • Албан томилолтын зардал гараагүй. Шагнал урамшуулалын зардлыг 100 хувиар хэмнэн ажиллалаа.	
5	Төсвийн тухай хуулийн дагуу санхүүгийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр хугацаанд нь тайлагнах;	Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.1, 54.4.2, 54.4.3, 54.4.4, 54.4.5 заасны дагуу санхүүгийн тайланг бэлтгэн хагас болон бүтэн жилээр нэгтгэн Нийслэлийн төрийн сангийн хэлтэст хянуулж тайлагнадаг. 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг төсвийн тухай хуулийн дагуу 07 сарын 20-ны дотор холбогдох байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна.	100
6	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ", нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагатай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулах 2026 оны хариуцлагын гэрээ 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/30 дугаартай гэрээ хийгдэж батлагдсан. Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагатай байгуулдаг "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ" байгуулагдаагүй байна.	100
7	Хууль, дүрмээр болон энэхүү гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд итгэмжлэлээр төлөөлөх, үр дүнг хариуцан тайлагнах;	Хууль, дүрмээр болон гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд шүүхийн аливаа маргаанд Нийслэлийн Засаг даргыг төлөөлөн оролцоогүй болно.	100
8	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллах;	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн "Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах хуваарь батлах тухай" А/02 дугаар тушаалаар нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн их цэвэрлэгээний хуваарийн дагуу 02 дугаар сарын 13-ны өдөр байгууллагын нийт 17 ажилтан Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Нарантуулын уулзвар хүртэл гудамж, зам талбайн хог хаягдал, цас мөсийг цэвэрлэж ажилласан.	100

9	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
10	Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах;	Дүрмээр хүлээсэн чиг үүргийнхээ дагуу тус байгууллага нь Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн сургуулийн өмнөх боловсролын 75 байгууллага, ерөнхий боловсролын 9 сургуулийн үдийн хоол, нийт 84 байгууллагад эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан 32 нэр төрлийн 130 гаруй хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй ханган ажиллаж байна. Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хариуцлагын гэрээний эхний хагас жилийн биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний газарт 06 дугаар сарын 12-ны өдрийн дотор хүргүүлсэн.	100
11	Албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2026 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлагдсантай холбогдуулан ажилчдын албан тушаалын цалинг 10 хувиар нэмж олгох саналыг Өмчийн харилцааны газарт 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр хүргүүлсэн боловч одоогоор хариу ирээгүй болно. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/379 дүгээр тушаалаар “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам” Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хүрээнд Чингэлтэй нэгдсэн эмнэлэгтэй 01 дүгээр сарын 02-ны өдөр гэрээ байгуулан 03 дугаар сарын 09-ний өдөр 16 ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 1 удаа хамруулахад нийт 800,000 төгрөг зарцуулсан. Жининь, Хөх хотын эрүүл мэндийн шинжилгээтэй аяллын гэрээг 05 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан. Байгууллагын 17 ажилтан 06 дугаар сарын 01-ний өдөр эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдаж нийт 10,000,000 төгрөгийг зарцуулсан. Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.9-д заасны дагуу сар шинийн баярыг тохиолдуулан 4 ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж 600,000 төгрөг, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилчдын 27 хүүхдэд гарын бэлэг өгч, нийт 1,620,000 төгрөгийг тус тус зарцуулж ажилласан.	100

		Байгууллагаас зохион байгуулсан 3 удаагийн сургалтад 17 ажилтан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон бусад байгууллагаас зохион байгуулсан 12 удаагийн сургалтад 8 ажилтан хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн.	
12	Алба хаагчдын сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах;	Тайлант хугацаанд сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан 1 ажилтанд 2 дугаар сарын 16-ны өдрийн Б/01 тоот тушаалаар сануулах сахилгын шийтгэл ногдуулсан. Мэдлэг ур чадвараа нэмэгдүүлэхэд онцгой анхаарч 1 ажилтанг “Отгонтэнгэр их сургууль”-ийн эрх зүйн ангид суралцахад нь дэмжиж ажиллаж байна. Ажилчдад монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтыг 04 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	100
13	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх;	Хүнсний бүтээгдэхүүний чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл аюулгүй хүнсийг захиалгын дагуу Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн сургуулийн өмнөх боловсролын 75 байгууллага, ерөнхий боловсролын 9 сургуулиудад хурдан шуурхай, чирэгдэлгүй нийлүүлэн ажиллаж байна.	100
14	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай” А/1843 дугаар захирамжийн дагуу тус байгууллагад оны 01 дүгээр сарын 13-ны өдөр хяналт шалгалтаар ирсэн албан хаагчдын хууль ёсны шийдвэрийг биелүүлж, шаардлагатай баримт бичгүүдийг тухай бүр нь гарган шалгуулж ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/233 дугаар “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны үр дүнг дүгнэх тухай” захирамжаар “Бүрэн хангалттай” үнэлгээгээр дүгнэгдсэн.	100
15	Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтүүдийн суурь түвшинг тодорхойлж, үзүүлэлтийн үр дүнг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийн хүрсэн үр дүнг жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцож тайлагнах, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;	Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс тус байгууллагад Хүнсний хангамжийн чанар-30, Хүнсний хангамжийн хүртээмж-52 гэсэн үзүүлэлтүүд хамаардаг болно. Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хамаарах заалтыг тусгаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
16	Чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн	Өөрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, стандарт болон Нийслэлийн үйл ажиллагааг Bagachuudkhuns.ub.gov.mn вэб хуудас, фэйсбүүкийн	100

	этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай бүр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах;	“Багачууд хүнс” ОНӨААТҮГ-ын албан ёсны цахим хуудсаар дамжуулж, сурталчилан таниулж ажиллаж байна.	
17	Байгууллага, аж ахуй нэгж, албан хаагчдын төлөвлөлтийн баримт бичгийг тогтвортой хөгжилд түшиглэсэн засаглалын шинэчлэлийн хүрээтэй уялдуулан боловсруулах, хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийн явц, үр дүнг тогтмол хянах, залруулах арга хэмжээг тухай бүр авч ажиллана;	Байгууллага, ажилчдын төлөвлөлтийн баримт бичгийг тогтвортой хөгжилд түшиглэсэн засаглалын шинэчлэлийн хүрээтэй уялдуулан боловсруулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр хангуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг тогтмол хянан ажиллаж байна.	100
18	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах;	2026 оны эхний хагас жилийн байдлаар иргэн, аж ахуй нэгж хуулийн этгээдээс, ажилтан, албан хаагчдын харилцаа хандлага болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол, санал, хүсэлт байхгүй болно. Тайлант хугацаанд нийслэлийн өргөдөл гомдлын цахим erp.ulaanbaatar.mn программаар ирсэн ажлаас чөлөөлөх 1 өргөдлийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн.	100
19	Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах, Нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	2026 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн удирдах ажилтны 12 удаагийн шуурхай зөвлөгөөнд оролцсон. Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 19 үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг заасан хугацаанд нь хүргүүлж ажилласан. Мөн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 6, 7, 10, 12 дугаар зарлагдсан хуралдаанд 25 удаагийн хуралд захирал Б.Мөнхнасан өөрийн биеэр оролцсон.	100
20	Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;	Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 06 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлсэн.	100
21	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Нээлттэй мэдээлэл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор бүрэн эхээр нь цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангах;	Байгууллагын цахим хаяг Bagachuudkhuns.ub.gov.mn -25, Shilen.gov.mn -77 үзүүлэлтийн дагуу нийт 102 мэдээ, мэдээлэл, Shilendans.gov.mn сайтад 2026 онд нийт 157 мэдээлэл нийтлэхээс 1-ээс 6 дугаар саруудад 66 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, үлдсэн 91 мэдээлэл хугацаа нь болоогүй ба үүнээс 5,000,000.00 төгрөгөөс дээш нийт 1,389,768.99 мянган төгрөгийн орлогыг, нийт 1,417,610.67 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан тухай бүр нь холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж тайлагнасан. Байгууллагын мэдээллийн самбарт санхүү, хүний нөөц, ажлын зар, дүрэм журам, сургалтын мэдээлэл, шинэ мэдээлэл, үйл явцыг тухай бүр нь оруулан ажиллаж байна.	100

22	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;	Тус байгууллага нь 2026 онд нийт төсөвт өртөг 4,823,084,000.00 мянган төгрөгийн төсөвтэй 1 нээлттэй тендер, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу төсөвт өртөг нь 20 сая төгрөгөөс доош өртөгтэй 6 бараа, 1 эд хөрөнгө худалдан авах гэрээ шууд байгуулах аргыг ашиглахаар төлөвлөгөөгөө tender.gov.mn сайтад байршуулан ажилласан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 2026 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгасан 27 багц ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 3 удаа зарлаж 20 багцад 9 аж ахуйн нэгж байгууллагатай тендерийн гэрээ байгуулан ажиллаж байна. Shilendans.gov.mn сайтад 2026 онд нийт 157 мэдээлэл нийтлэхээс 1-ээс 6 дугаар саруудад 66 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, үлдсэн 91 мэдээлэл хугацаа нь болоогүй ба үүнээс 5,000,000.00 төгрөгөөс дээш нийт 1,389,768.99 мянган төгрөгийн орлогыг, нийт 1,417,610.67 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан тухай бүр нь холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж тайлагнасан.	100
23	Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны газраас урьдчилан зөвшөөрөл авч, хэрэгжүүлэх;	Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, уялдуулсан ажил байхгүй болно.	100
24	Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж байгаа аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх;	Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээлэл болон нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстээс гаргаж буй мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь bagachuudkhuns.ub.gov.mn веб сайт болон фэйсбүүкийн "Багачууд хүнс" ОНӨААТҮГ-ын албан ёсны цахим хуудсанд тавин олон нийтэд түгээн ажиллаж байна.	100

ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
"БАГАЧУУД ХҮНС" ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ



Б.МӨНХНАСАН